

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
/2022 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар/

2022 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Зүйл заалтын дэс дугаар	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<i>Нэг .Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол</i>					
1.	Хурлын хуралдааны дэг батлах тухай 2022.03.28 №01 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2.Хурлын хуралдааны дэгийг сахиж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын алба, хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4, 5, 6, 7 дугаар болон ээлжит бус 3 дугаар хуралдааныг дэгийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100	
2.	Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай 2022.03.28 №02 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.	2.Энэ дүрмийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд үүрэг болгосугай. 3. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүй, өргөдлийн хороонд даалгасугай.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг Төлөөлөгчдөд цахим болон цаасан хэлбэрээр сурталчилж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	
3.	Хурлын дүрэм батлах тухай 2022.03.28 №03 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2.Хурлын дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албанд тус тус даалгасугай.	Хурлын дүрмийг бүхий л үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэмд заасны дагуу 3 Төлөөлөгчийн эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж, 7 Төлөөлөгчид буцалтгүй мөнгөн тусламж олгосон байна.	100	

4.	Хурлын Зөвлөл байгуулах тухай 2022.03.28 №05 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж, хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхын санал авсан дараах нэр бүхий Төлөөлөгчдийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүнээр сонгож, баталсугай.	2. Хууль тогтоомж, холбогдох журмын хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг 7 Төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан бөгөөд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тайлант хугацаанд өргөн барьсан асуудлын хүрээнд 15 удаа хуралдаж, 16 тогтоол шийдвэрийг баталсан байна.	100	
5.	Хурлын хороог байгуулж, үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах тухай 2022.03.28 №06 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хурлын хороодыг байгуулж, Хурлын хорооны үйл ажиллагааны журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны үйл ажиллагааны журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хурлын хороодоос 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2022 оны 03 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын хороод тайлант хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр 71 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 10 удаагийн удирдамж, төлөвлөгөөний дагуу 69 ажлыг зохион байгуулж, чиг үүрэг давхцсан болон удирдлагын заалтаар 2 ажил хойшилж, биелэлт 97,1 хувьтай байна. Хурлын хороодын ажиллахад шаардагдах зардлыг тухай бүр Хурлын төсвөөс санхүүжүүлээ.	97,1	
6.	Чингэлтэй дүүргийн зарим хороодын хэсгийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай 2022.03.28 №07 Төвлөрлийг сааруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, хүндрэл чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн зарим	2. Хэсгийн хуваарийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан тухайн хэсэгт хамаарах иргэн, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн болон эд хөрөнгийн бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулахыг	Шинээр байгуулагдсан 20, 21, 22, 23, 24 дүгээр хороодоос хорооны байр нь шийдвэрлэгдсэн 20, 24 дүгээр хороодын иргэн, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн болон эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэх судалгааг хийлээ. Үүнд: Иргэний үнэмлэх солиулах-22,338 иргэн	70	Шинээр байгуулагдсан 21,22,23 дугаар хороодын байр, төсөв санхүү, хүний нөөцийн асуудлыг 2022 оны төсвийн тодотголд

	хороодын хэсгийн хуваарийг хавсралт ёсоор шинэчлэн тогтоосугай.	дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай. 3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Эд хөрөнгийн гэрчилгээ солиулах-6,682 иргэн Хуулийн этгээдийн гэрчилгээ солиулах-129 аж ахуй нэгж байна. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Мэдээлэл технологийн газарт дээрх судалгаа мэдээллийг хүргүүлснээс 89 иргэний иргэний үнэмлэхийг сольж, хаягийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан байна. Газрын албаны мэдээллийн сангаас шинэ хаягаар кадастрын зураг хэвлэгдэхгүй байгаа учраас Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг солих ажил хүлээгдэж байна.		тусган шийдвэрлэснээр хэрэгжилтийг ханган ажиллана.
7.	Чиглэл болгох тухай 2022.03.08 №08 Дүүргийн зарим хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан дүүргийн 7, 12, 16, 17, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр хороодын нутаг дэвсгэрийн зааг, эргэлтийн цэгийн солбицлын саналыг хавсралт ёсоор дэмжсүгэй.	2.Эргэлтийн цэгийн солбицлын саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д чиглэл болгосугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны 1/738 дугаарын албан бичгээр тус тогтоолыг Нийслэлийн Засаг даргад уламжлан, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/43 дугаар тогтоолоор Чингэлтэй дүүрэгт шинээр байгуулагдсан 5 хорооны нутаг дэвсгэрийн хилийн зааг, цэг тэмдэгт, солбилцлыг баталлаа.	100	
8.	Хаягийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай 2022.03.28 №09 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу, 16 дугаар байрны иргэн, хуулийн этгээдийн өд хөрөнгийн хаягийн бүртгэлийг эд хөрөнгө нь байршиж байгаа нутаг дэвсгэрийн харьяалалд шилжүүлж, хаягийн бүртгэлийг засаг, захиргаа,	2.Иргэн хуулийн этгээдийн эд хөрөнгийн хаягийн бүртгэлийн өөрчлөлтийг зохих этгээдэд мэдээлж, Улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг	Дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу, 16 дугаар байрны иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн хаягийн бүртгэлийг эд хөрөнгө нь байршиж байгаа нутаг дэвсгэрийн харьяалалд шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг дүүргийн Засаг даргын А/132 дугаар захирамжаар байгуулагдан хэрэгжилтийг зохион байгууллаа. Тус ажлын хэсэг нь 4 дүгээр хороонд байрлах 16 дугаар байрны хүн ам, эд хөрөнгийн эрхийн улсын	70	

	нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцүүлэх ажлыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай.	зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	бүртгэлийн судалгааг гаргахад 0-15 насны 43 хүүхэд, 16 наснаас дээш насны 83 иргэн байгаа бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээ өөрчлөх 45 иргэн, түрээслэн амьдардаг 23 иргэн байв. Хаягийн бүртгэлийн өөрчлөлтийг хийхэд 3,099,000 төгрөг шаардлагатай байна. Иргэний Улсын бүртгэлийн мэдээллийн санд хаягийн өөрчлөлтийг тусгуулахаар Хяналтын Улсын байцаагчийн дүгнэлтийг холбогдох материалын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлээд байна.		
9.	Үнэлгээний хороо бүрэлдэхүүнд иргэдийг оролцуулах тухай 2022.03.28 №10 Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан Чингэлтэй дүүргийн харьяат иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.	2.Хавсралтад нэр дурдсан иргэдийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Улс, нийслэл, дүүргийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд дүүрэгт хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 29 Үнэлгээний хороо байгуулагдсан бөгөөд дээрх Үнэлгээний хороодод АЗ гэрчилгээний сургалтад хамрагдсан Чингэлтэй дүүргийн харьяат 1 иргэнийг оролцуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5 дах хэсгийг ханган ажиллалаа.	100	
10.	Дүүргийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2022.03.28 №11 Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.		Дүүргийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд байсан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын МАН-ын бүлгийн дарга И.Даваадоржийг чөлөөлж, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Х.Азбаярыг томилон ажиллаж байна.	100	

11.	“Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах эхчүүдийг уламжлах тухай 2022.03.28 №12 Дүүргийн харьяат олон хүүхэд төрүүлж, өсгөн “Алдарт эх” I зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрсийг нэгдүгээр, “Алдарт эх” II зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2.Хавсралтад нэр дурдсан эхчүүдийг “Алдарт эх” I, II зэргийн одонгоор шагнуулахаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Олон хүүхэд төрүүлж өсгөн, Алдарт эх 1,2 дугаар зэргийн одонгоор шагнуулах болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат нийт 498 эхийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлав.	100	
12.	Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай 2022.03.28 №13 2022.06.30 №19 2022.09.19 №23 2022.11.09 №27 2022.12.15 №33	Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулах болзол хангаж, байгууллага, хамт олноос тодорхойлж, ирүүлсэн дараах иргэдийг дэмжиж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.	Төрийн дээд цол, одон, медалиар шагнуулахаар байгууллага, хамт олноосоо тодорхойлгдож ирсэн Чингэлтэй дүүргийн харьяат 768 иргэний тодорхойлолт, материалыг хүлээн авч, хэлэлцэн дэмжиж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлав.	100	
13.	Дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022.06.10 №15 Дүүргийн 2022 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.		Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	-	
14.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай 2022.06.30 №16 Монгол Улсын Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Захиргааны	2.Энэ тогтоолыг холбогдох байгууллагад хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн	Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4159 дугаарт бүртгэлтэй байсан тус тогтоолыг хүчингүй болгуулахаар тогтоол болон холбогдох материалыг Монгол Улсын Хууль зүй, дотоод	90	

	хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй “Газрын үнэлгээний зэрэглэл (бүс)-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх газрын зааг, хязгаарыг тогтоох тухай” дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.	Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	хэргийн яаманд 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 1/319 тоот албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлэв.		
15.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дүүргийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай 2022.06.30 №17 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дүүргийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.	2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хууль тогтоомжийн хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь Ажлын албатай болсонтой холбогдуулан нарийн бичгийн даргаар тус зөвлөлийн Ажлын албаны даргыг томилж, харьяалах чиг үүрэг бүхий 19 албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2022 онд 4 бүлэг бүхий 37 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 36 ажил бүрэн хэрэгжиж, 1 ажил хойшилж, биелэлт 97,2 хувьтай байна.	97,2	
16.	Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн Зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах тухай 2022.06.30 №18 Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах үүрэг бүхий Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн бүрэлдэхүүнд 10 байгууллагын төлөөлөл бүхий 19 хүн ажиллаж байна. Дүүрийн хэмжээнд 2022 онд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэлээр 3 бүлэг бүхий 17 ажлыг зохион байгуулж, хэрэгжилт 100 хувьтай байна.	100	

17.	Хурлын Ажлын албаны орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай 2022.06.30 №20 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэгдүгээр, Хурал дахь Намын бүлгийн Ажлын албаны бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хоёрдугаар, Хурлын даргын бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.	2.Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэхийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүрэг гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд үүрэг болгосугай.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны даргын 2022 оны А/04 дүгээр тушаалаар ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Төрийн захиргааны 12, Төрийн үйлчилгээний 3, Улс төрийн -4 албан тушаалын тодорхойлолтыг холбогдох дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Төрийн захиргааны 12 албан тушаалын тодорхойлолтыг хянуулахаар холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн, батлууллаа. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийн хүрээнд нийт 21 албан хаагч ажиллаж байгаагаас Төрийн захиргааны 13, Төрийн үйлчилгээний 3, Улс төрийн 4 албан хаагчтай тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна.	100	
18.	Дүүргийн 2022 оны хагас жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2022 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай 2022.09.19 №21 Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг хэлэлцээд "Хангалттай" гэж дүгнэсүгэй. 2.Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний иргэнд эзэмшүүлэх газрын тоо, хэмжээ, төрийн болон төсөвт байгууллагын	4.Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит долоодугаар хуралдаанд дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг танилцуулан тус хуралдааны 30 дугаар тогтоолоор хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхын саналаар дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг "Хангалттай" гэж дүгнэв.	70	

	зайлшгүй хэрэгцээнд олгох газрын тоо, хэмжээг тус тус хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.			
19.	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай 2022.09.19 №22 Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд урлаг, спортын болон хүндэтгэлийн бусад арга хэмжээний бэлтгэлийг сайтар хангаж, иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагыг хамруулан зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д зөвшөөрсүгэй.	2.Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт орших Чингэлтэй хайрхныг тайх их тахилгын ёслолыг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.	Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт орших Чингэлтэй хайрхныг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр тахиж, иргэдийн дунд уламжлалт уралдаан тэмцээн, урлаг соёлын олон талт арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.	100	-
		3.Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойн медаль, медалийн үнэмлэхийн эх загварыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлөөр батлуулж, захиалан хийлгүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай.	Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойг тохиолдуулан дүүргийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмрээ оруулж ажилласан үе үеийн ахмад ажилтан, төрийн албан хаагч, иргэдийг шагнаж, хүндэтгэл үзүүлэх ойн медаль, медалийн үнэмлэхийн эх загварыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2022 оны 08 дугаар тогтоолоор батлуулан, захиалан хийлгүүлэв.		
		4.Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажил зохион байгуулахад шаардагдах зардлыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн санхүүжүүлэхийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Мөнхбат), Засаг дарга (Н.Батсүмбэрэл) нарт зөвшөөрсүгэй. 5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн	Дүүргийн 30 жилийн ойг тэмдэглэн ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар байгуулсан бөгөөд ойн хүрээнд зохион байгуулах 203 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна. Ой тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан бөгөөд Төсвийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс 64,401,100 төгрөгийн, Засаг даргын Тамгын газраас		

		Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	99,132,500 төгрөгийн зардлыг тус тус гаргасан байна.		
20.	Төрийн дээд шагналд уламжлах тухай 2022.09.19 №24 Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан дүүргийн хүн амын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бодит, үр дүн бүхий жишиг ажлуудыг санаачлан хэрэгжүүлж, Монгол Улсын хөгжлийн бодлого зорилт, Нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийн биелэлтийг хангах, төсөв санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд идэвх, санаачилга гарган улс, нийслэл, дүүргийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулан ажилласан тус дүүргийн төр, захиргааны байгууллагын үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчдын хичээл зүтгэл, амжилт ололтыг үнэлж, “Чингэлтэй дүүрэг”-ийг Төрийн дээд шагнал болох “Алтан гадас одон”-оор шагнуулах саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.	2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Нийслэлийн Чингэлтэй дүүргийг Алтан гадас одонгоор шагнуулахаар дэмжсэн тогтоолыг дүүргийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1/2729 тоот албан бичгээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлав.	70	
21.	Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцох Төлөөлөгчийг сонгох тухай 2022.09.19 №25 Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын хуралдаанд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлөн оролцох Төлөөлөгчөөр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын	2.Төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцох ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	“Нутгийн удирдлага-30” эрдэм шинжилгээний хурал болон Нутгийн удирдлагын Төлөөллийн байгууллагын Анхдугаар хуралдаан 2022 оны 11 дүгээр сарын 25-нд болсон бөгөөд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Мөнхбат оролцож, дүүрэг орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх, тулгамдаж буй асуудлаар байр сууриа илэрхийлэв.	100	

	дарга Бүлтэнхүүгийн Мөнхбатыг сонгож, оролцуулсугай.				
22.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2022.11.09 №26 Дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 15 дугаар тогтоолын 3 дахь заалтын төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагуудад олгосон төсөв зарцуулах эрхийг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.		Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	
23.	Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай 2022.12.15 №28		Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	
24.	Дүүргийн зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг нэгтгэх тухай 2022.12.15 №29 1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн "Ахмадын амралт, сувилал" орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, Цонжин болдог дахь "Чингэлтэй ахмадын амралт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг тус тус "Хоймор хайрхан амралт, сувилал" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газартай нэгтгэж, өөрчлөн байгуулсугай. 2.Чингэлтэй дүүргийн "Ахмадын амралт, сувилал" орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, Цонжин болдог дахь "Чингэлтэй ахмадын амралт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн	3.Чингэлтэй дүүргийн "Ахмадын амралт, сувилал" орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, Цонжин болдог дахь "Чингэлтэй ахмадын амралт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааг дуусгавар болгон, "Хоймор хайрхан амралт, сувилал" ОНӨТҮГ-ын мэдээлэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	

	хөрөнгийг тус тус “Хоймор хайрхан амралт, сувилал” ОНӨТҮГ-т шилжүүлсүгэй.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.			
25.	Дүүргийн Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2023 оны төлөвлөгөө батлах тухай 2022.12.15 №30 1.Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд "Хангалттай" гэж дүгнэсүгэй. 2.Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	3.Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	
26.	Хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг шинэчлэн тогтоох тухай 2022.12.15 №31 Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Чингэлтэй хайрхан уулын салбар уулс болох Шадивлан, Яргайт, Яргайтын богино, Гүнт, Жигжид, Майхан толгой, Ойн булаг орчмын хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2.Шинэчлэн тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	

27.	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2022.12.15 №32	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.	Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг чиг үүрэг бүхий 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.	100	
28.	Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах тухай 2022.12.15 №34 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг үе шаттай шийдвэрлэх, дүүргийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, эрх тэгш байдлыг хангах чиг үүрэг бүхий Эмэгтэйчүүдийн зөвлөлийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулсугай.	2.Эмэгтэйчүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, зохион байгуулсан ажлын тайланг жил бүрийн эцэст дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх эмэгтэйчүүдийн зөвлөлд даалгасугай. 3.Эмэгтэйчүүдийн зөвлөлийн үйл ажиллагаанд бодлогын болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Мөнхбат), Засаг дарга (Н.Батсүмбэрэл) нарт тус тус даалгасугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	
Хоёр .Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн тогтоол					

29.	Хуралдааны бэлтгэл хангуулах тухай 2022.04.28 №01 Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиглэлээр эрхлэх асуудлынхаа хүрээнд 2022 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөний төслөө боловсруулж, Хурлын Зөвлөлд ирүүлэхийг Хурлын хороодын дарга нарт чиглэл болгосугай.	2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, Төлөөлөгч, Засаг дарга, иргэд байгууллагаас Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын саналыг авч, урьдчилан бэлтгэж, Хурлын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хурлын Зөвлөлд тайлагнахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд үүрэг болгосугай.	Хурлын хороодоос 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг ирүүлэх чиглэлийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2/162 дугаар албан бичгээр Хурлын хороодын дарга нарт хүргүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2022 оны 03 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	
30.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2022.05.13 №02 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж ажиллахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	Хурлын Зөвлөл өргөн барьсан асуудлын хүрээнд нийт 11 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 42 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс 39 асуудлыг хэлэлцэж, төлөвлөгөөний биелэлт 92,8 хувьтай байна.	92,8	
31.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооноос 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2022.05.13 №03	2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Хурлын хороодын дарга нарт үүрэг болгосугай.	Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын хороод тайлант хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр 71 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 10 удаагийн удирдамж, төлөвлөгөөний дагуу 69 ажлыг зохион байгуулж, чиг үүрэг давхцсан болон	97,1	

	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодоос 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	удирдлагын заалтаар 2 ажил хойшилж, биелэлт 97,1 хувьтай байна.		
32.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн Хуралдааны дэг батлах тухай 2022.05.13 №04 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралт ёсоор баталсугай.	2. Хуралдааны дэгийг сахиж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүд хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.	Тайлант хугацаанд Хурлын Зөвлөл өргөн барьсан асуудлын хүрээнд нийт 15 удаа дэгийн дагуу хуралдсан байна.	100	
33.	Чиглэл болгох тухай 2022.05.13 №05 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм цахим бодлогын хөгжлийн хороо, Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны санал, дүгнэлтийг холбогдох хэлтэс албадад хүргүүлж, үйл ажиллагаа болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг Хурлын ажлын (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд чиглэл болгосугай.	Хурлын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийн мөрөөр зохион байгуулж байгаа ажилд хяналт тавьж, хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны санаачилгаар Эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээг цаасан хэрэглээнээс цахим хэрэглээнд шилжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үзлэгийн бүртгэл мэдээллийн цахим системийг бий болгож, эрүүл мэндийн цахим бүртгэл, өвчтөний түүх, эмчийн цахим жор, үзлэгийн мэдээллийн сан бүхий бүртгэл мэдээллийн системийг дүүргийн 9, 12, 15, 16 дугаар хороодын ӨЭМТ-дэд нэвтрүүлээ. Мөн Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны санаачилгаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг илрүүлэх, далд эдийн засгийг бууруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгөх зорилго бүхий татвар төлөгчдийн	100	

			бүртгэлийн chglmap.mta.mn нэгдсэн системийг нэвтрүүлээд байна.		
34.	Төсөл дэмжих тухай 2022.06.22 №06 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хорооноос санаачилсан дүүргийн иргэдэд хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн “Чингэлтэйн хог баялаг болно” төслийн саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Төсөл арга хэмжээний тайлан мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд тайлагнахыг Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хорооны дарга (Т.Идэрцагаан)-д үүрэг болгосугай.	Дүүргийн иргэдэд хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн “Чингэлтэйн хог баялаг болно” төслийг 2022 оны 07 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд 3 сарын хугацаатай хэрэгжүүлээ. Төслийн хүрээнд: -Дүүргийн 1-24 хороодын Иргэний танхимаар “Чингэлтэйн хог баялаг болно” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил, -“Цэвэр хот, хотоо хайрлая” дууг хэн сайн дуулах вэ хүүхдийн дууны сошиал уралдаан, -Хэсгийн ахлагч нарын дунд “Манай хэсэг хогоо ангилдаг” уралдааныг тус тус зарлан, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллалаа. Мөн дүүргийн 1-24 хорооны 180 хэсгийн ахлагч нарыг хог хаягдал, байгаль хамгаалах сургагч багшаар бэлтгэлээ.	100	
35.	Санал дэмжих тухай 2022.06.29 №07 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны санаачилсан “Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төсөл”-д санал авах нийтийн сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2022 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнахыг Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга (Д.Ядамжав)-д үүрэг болгосугай.	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооноос “Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төсөл”-д санал авах зорилгоор нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг Хурлын Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон дүүргийн 1-24 дүгээр хорооны иргэдийн дунд зохион байгууллаа. Мөн иргэдээс цахимаар санал авч нэгтгэв.	100	

36.	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойн медаль, медалийн үнэмлэхийн эх загварыг батлах тухай 2022.09.21 №08 Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан дүүргийн хөгжил, цэцэглэлтэд бодитой хувь нэмрээ оруулж ажилласан үе үеийн ахмад ажилтан, төрийн албан хаагч, иргэдийг шагнаж, хүндэтгэл үзүүлэх “Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойн медаль”-ийн эх загварыг нэгдүгээр, үнэмлэхийн эх загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2.Ойн медаль, медалийн үнэмлэхийн батлагдсан эх загварын дагуу захиалан хийлгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай. 3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд үүрэг болгосугай.	Ойн медаль, медалийн үнэмлэхийг батлагдсан эх загварын дагуу ЧДХААА УАЗ Б22/13 гэрээгээр “Гоёл трейд” ХХК-д захиалан 5100 ширхэг хийлгүүлэн, дүүргийн хөгжилд хувь нэмрээ оруулсан үе үеийн ахмад ажилтан, албан хаагчид, иргэдэд гардуулж байна.	100	
37.	Уриалга гаргах тухай 2022.09.21 №09 Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн хүүхэд, залуучууд, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хандсан уриалгыг хавсралт ёсоор баталсугай.	2.Энэхүү уриалгыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэх, сурталчлах, холбогдох дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохион байгуулалттай арга хэмжээ авах, ойн хүрээнд хийгдэх төсөв хөрөнгө шаардлагатай зарим ажил, арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх, хөрөнгө босгох чиглэлээр орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бус байгууллага, нутаг дэвсгэрийн аж ахуйг нэгжүүдтэй хамтран ажиллахыг Ойн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг (ахлагч Д.Отгонбаатар), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа), дүүргийн Засаг	Дүүргийн 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагуудаас саналыг авч 203 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгууллаа. Дүүргийн 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаанаас дурдвал: -Улс, аймгийн цолтой хүчит 256 бөхийн барилдаан -Иргэдийн баярын арга хэмжээ -Чингэлтэй хайрханы тахилгыг тус тус зохион байгууллаа. Дүүргийн иргэд, олон нийтэд соёл урлагийн үйл ажиллагааг хүргэх хүрээнд 17 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 4000 гаруй иргэдийг 5 удаагийн сургалт, 1 удаагийн аянд хамруулсан бөгөөд нийт 25 удаагийн арга хэмжээнд 19000 гаруй иргэд, ажилтан албан хаагчдыг хамрагдсан байна.	100	

		даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т тус тус үүрэг болгосугай. 3.Ойн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, мэдээллийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд тайлагнахыг Ойн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг (ахлагч Д.Отгонбаатар), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа), дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т тус тус даалгасугай.	Дүүргийн иргэдийн бие бялдарыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд 30 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 50220 гаруй иргэдийг оролцуулсан байна.		
38.	Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай 2022.09.28 №10 Олон Улсын “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн харьяат ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд зөвшөөрсүгэй.	"Олон Улсын ахмадын өдөр"-ийн баярын өдрийг тохиолдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хамтран улс дүүрэг, орон нутгийн хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж ажилласан дүүргийн харьяат 4000 ахмад настанд хүндэтгэл үзүүлэв.	100	
39.	Санал дэмжих тухай 2022.09.28 №11 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүй, өргөдлийн хорооны санаачилсан дүүргийн төрийн албан хаагчид болон иргэдийн хамтын ажиллагааг	2.Зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Ёс зүй, өргөдлийн хороо (дарга	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүй, өргөдлийн хорооноос “Төрийн албан хаагч, иргэд хоорондын харилцаа хандлага, хамтын ажиллагааг сайжруулах нь” сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалт, хэлэлцүүлэгт	100	

	сайжруулахад чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	Б.Дэлгэрбат)-нд үүрэг болгосугай.	дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчид, Зөвлөлийн гишүүд, Хурлын хороодын гишүүд, Ажлын алба болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, хороодын Засаг дарга, албан хаагчид, хэсгийн ахлагчид болон сайн дурын иргэдийн зөвлөлийн ахлагч, гишүүд, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчид нийт 500 гаруй ажилтан албан хаагчид хамрагдав.		
40.	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойн хүрээнд үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах тухай 2022.09.30 №12 Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд улс, аймгийн цолтой хүчит 256 бөхийн барилдааныг 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа), Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т тус тус даалгасугай.	2.Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд зөвшөөрсүгэй.	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд улс, аймгийн цолтой хүчит 256 бөхийн барилдааныг 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Бөхийн өргөөнд зохион байгуулсан бөгөөд шаардагдах зардал 19,537,100 (арван есөн сая таван зуун гучин долоон мянга нэг зуу) төгрөгийг Ажлын албаны даргын 2022 оны А/128 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллав.	100	
41.	Төсөл дэмжих тухай 2022.10.19 №13 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ногоон хөгжил, газрын харилцааны хорооноос санаачилсан “Хашаандаа мод тарья” төслийн саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Ногоон хөгжил, газрын харилцааны хороо (дарга Н.Бямбагэрэл)-нд үүрэг болгосугай.	Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшилсон.	-	Хаврын мод тарих өдрөөр тус арга хэмжээг зохион байгуулахаар хойшлуулав.
42.	Төсөл дэмжих тухай 2022.11.3 №14	2.Төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн	Хог хаягдал нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох, иргэдэд байгальд ээлтэй амьдралын	100	

	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэр үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хорооноос санаачилсан “Чингэлтэйн хог баялаг болно” төслийн хүрээнд зохион байгуулах хаягдал нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох, иргэдэд байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн хороодын хэсгийн ахлагчдыг сургагч багшаар бэлтгэх төслийн саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	Хурлын Зөвлөлд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэр үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо (дарга Т.Идэрцагаан)-нд үүрэг болгосугай.	хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургагч багшаар бэлтгэх төсөлд Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын 180 хэсгийн ахлагчдыг хамруулсан.		
43.	Санал дэмжих тухай 2022.11.3 №15 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооноос санаачилсан дүүргийн 1-24 хороод, ерөнхий боловсролын сургууль болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн ажилтнуудад мэргэжлийн үйлчилгээг чанартай хүргэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн “Нийгмийн ажил-Мэргэжлийн үйлчилгээ” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо (дарга Т.Уламбаяр)-нд үүрэг болгосугай.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооноос санаачлан хороодын, халамжийн, Ерөнхий боловсролын сургууль, Өрхийн Эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтнуудын ажлын байрны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, гарц шийдлийг хэлэлцэх, хороодын Хамтарсан багийн гишүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, гэр бүл, хүүхэд хамгаалалд мэргэжлийн үйлчилгээг чанартай хүргэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Нийгмийн ажил-Мэргэжлийн үйлчилгээ” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг дүүргийн 80 нийгмийн ажилтнуудыг хамруулан 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгууллаа.	100	

44.	Санал дэмжих тухай 2022.11.3 №16 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооноос санаачилсан дүүргийн 1-24 дүгээр хорооны жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын саналыг дэмжиж, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбаа)-нд даалгасугай.	2.Зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо (дарга Ц.Содхүү)-нд үүрэг болгосугай.	Дүүргийн 1-24 дүгээр хорооны иргэд болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүү, татварын талаарх анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 19-өөс 23-ны өдрүүдэд зохион байгуулж, 30 иргэнийг хамрууллаа.	100	
-----	--	---	---	-----	--

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА